

“МЭРГЭЖИЛТНИЙГ ЧАДВХЖУУЛСНААР ДУЛААН ХАНГАМЖИЙН ҮР АШИГ ДЭЭШИЛЖ, ХЭМНЭЛТИЙГ БИЙ БОЛГОХ НЬ” ТӨСӨЛ

ТӨСЛИЙН ТУХАЙ:

Монгол орон өвөлдөө -40°C хүртэл хүйтэргэдэг, эрс тэс цаг ууртай тул дулааны хангамж нь хүмүүсийн амьдралын салшгүй нэгэн хэсэг болдог. Улаанбаатар хотод түгээмэл ашиглагддаг дулааны хуучин халаалтын системүүд нь их хэмжээний эрчим хүчиний үр ашиггүй хэрэглээг үүсгэхээс гадна хүрээлэн буй орчны агаарын чанарт сөргөөр нөлөөлдөг. Сүүлийн жилүүдэд, дулааны эрчим хүчиний эрэлт ихэссэн ч нийлүүлэлт нь ихсэхгүй байгаа нь Улаанбаатар болон бусад хотуудад сорилт болж байна.

Дээрх асуудлыг шийдвэрлэхийн тулд, орчин үеийн байгаль орчинд ээлтэй тохируулга, технологи болон шахуургын системийг суурилуулах, ажиллуулах, ашигт ажиллагааг хангах мэдлэгтэй мэргэжилтнүүдийг бэлтгэх сургалтын агуулгыг хөгжүүлэн нэвтрүүлэх шаардлагатай.

Тиймээс энэхүү асуудлыг шийдвэрлэхэд ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны (BMZ) төр, хувийн хэвшлийн түншлэл develoPPP.de хөтөлбөрийн хүрээнд WILO SE групп, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ) хамtran энэхүү төслийг хэрэгжүүлж байна.

ХАМТЫН АЖИЛЛАГАА:

01



Багш нарыг чадавхжуулахад “Түншлэлд сууриссан техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт” төсөлтэй

02



Барилгын дулаан алдагдлыг бууруулахад халаалтын системийн шинэчлэхэд “Эрчим хүчиний хэмнэлттэй барилга угсралтын чадавхыг хөгжүүлэх стратегийн нэгдэл” төсөлтэй

03



Түншлэгч Дархан-Уул аймаг дахь ПК-д сантехникийн чиглэлийн мэргэжлийн зөвлөл байгуулахад “Үр чадварыг хөгжүүлэх” төсөлтэй

ЗОРИЛГО:

Орчин үеийн технологийг ашиглах мэргэшсэн боловсон хүчинийг мэргэжлийн боловсрол, сургалтаар бэлтгэх замаар Монгол Улсын дулаан хангамжийн системд эрчим хүчиний хэмнэлтийг нэвтрүүлэх.

Захиалагч:	ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны (BMZ) develoPPP.de хөтөлбөрийн хүрээнд
Хамtran санхүүжүүлэгч:	WILO SE групп
Байршил:	Улаанбаатар хот, Дархан-Уул аймаг
Түншлэгчид:	<ul style="list-style-type: none">“Берлин хотын үр чадвар ирээдүйг бүтээнэ” ТББ“ХБНГУ-ын хилийн чанд дахь ЕБС-уудын хэрэг эрхлэх газар” (ZfA)
Хэрэгжүүлэгч байгууллага:	<ul style="list-style-type: none">Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамБоловсрол, шинжлэх ухааны яамБарилга хот байгуулалтын яам
Хугацаа:	2021.09 – 2024.08



ҮР ДҮН:



БОГИНО ХУГАЦАНЫ СУРГАЛТ:

Дадлага ажилд чиглэсэн чадамжийн гэрчилгээ олгох сургалтын хөтөлбөрийг боловсруулж, батлуулав.



ЧАДАМЖИД СУУРИЛСАН СУРГАЛТ:

Сантехник, Халаалт, Агааржуулалтын Төхөөрөмжийн Техникчийн хөтөлбөрт “Эрчим хүчний хэмнэлттэй халаалтын систем уграх” чадамжийн нэгжийг нэмэлтээр оруулав.



ЦАХИМ СУРГАЛТ:

Сургалтын агуулгыг цахим хэлбэрт шилжүүлж байна.



ДАДЛАГЫН ОРЧИН:

Түншлэгч сургуулиудад эрчим хүчний хэмнэлттэй дулаан хангамжийн дадлага-сургалтын үзүүлэн суурилуулж дадлагын орчныг бүрдүүлж байна.



Түншлэгч 2 политехник коллеж (ПК)-ийн дэд бүтцийг эрчим хүчний хэмнэлттэй болгон шинэчлэх явцад МБС-ын багш нарыг чадавхжуулав.



Засварын өмнө



Засварын дараа

Нийтэлсэн:
Холбоо барих:

Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг

Беате Диппмар
“Мэргэжилтнийг чадавхжуулснааар дулаан хангамжийн үр ашиг дээшилж, хэмнэлтийг бий болгох нь” төсөл
Найман зовхис барилгын IV давхар, Сөүлийн гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14251, Монгол улс
Утас: 70005340
И-мэйл: beate.dippmar@giz.de
Вэб: www.giz.de/mongolia

Огноо:

2023 оны 03-р сар



ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ НАСОС АШИГЛАХАД ГАРСАН ҮР ДҮН:

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ НАСОС:
Wilo Stratos MAXO-D 40/0,5 – 16 PN6/10

ХУУЧИН НАСОС:
Wilo Ph401

VS

900

**ЧАДАЛ
(ватт)**

10

4536

**ЖИЛИЙН ЦАХИЛГААНЫ
ХЭРЭГЛЭЭ (кВт.ц)**

50

1361

**НҮҮРСНИЙ ХЭРЭГЛЭЭ
7 САРААР (кг)**

15

3.583

**СО2 ЯЛГАРУУЛАЛТ
(шууд) (тонн)**


0.04

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ БАРИЛГЫН СТАНДАРТ, ОЛОН НИЙТИЙН ОЙЛГОЛТЫГ САЙЖРУУЛАХАД:

Халаалтын системийн талаарх Европ болон Монголын стандарт, норм, дүрмийн талаарх хэлэлцүүлгийг салбарын мэргэжилтнүүдийн дунд зохион байгуулна. Эрчим хүчний хэмнэлттэй халаалтын системийн талаарх олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх зорилгоор бодит төслүүдийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

МОНГОЛ, ГЕРМАН УЛСЫН МБС-ЫН СУРАЛЦАГЧ СОЛИЛЦОО:

Хоёр орны соёл болон мэргэжлийн мэдлэг мэдээллийг солилцох, харилцан суралцах зорилготой солилцооны хөтөлбөрийг ХБНГУ-ын “Хилийн чанад дахь ЕБС-уудын хэрэг эрхлэх газар” (ZfA), “Берлин хотын ур чадвар ирээдүйг бүтээнэ” ТББ-тай хамтран хэрэгжүүлж байна.



Bundesamt für
Auswärtige Angelegenheiten
Zentralstelle für das Auslandsschulwesen

HandWerk stiftet
►► Zukunft

Нийтлэлийн агуулгыг Монгол дахь GIZ хариуцна.

Хамтран хэрэгжүүлэгч:



Дизайн/Зураг:
Захиалагч:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
Боловсрол, шинжлэх ухааны яам
Барилга хот байгуулалтын яам

Монгол дахь GIZ
ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн яам (BMZ)